1. MNS-ISO 5457-0:2003 стандартаар тогтоосон А4 дэвсгэртийн хэмжээг сонгоно уу.

   A. 420x594 B. 297x420 C. 210x297 D. 148x210

2. Изометрийн тэнхлэгийг 30, 60, 90 градусын өнцөгтэй гурвалжин шугам ашиглан байгуулах аргыг харуулсан зургийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

3. Биетийн гурван талыг (урт, өргөн, өндөр) нэг дүрслэлээр харуулж хэлбэр, хэмжээг нь ойлгомжтой дүрсэлдэг проекцлолын аргыг сонгоно уу.

   A. тэгш өнцгийн проекц B. аксонометр проекц
   C. хэвтээ ба босоо проекц D. төвийн ба параллел

4. Зурагт үзүүлсэн биетийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн хариуг сонгоно уу.





A.



B.



C.



D.

5. Ажлын зураг зурахын өмнө зургийн дэвсгэрт дээр эхлээд хүрээ шугам татах, үндсэн бичээс хийх хүснэгтээ зурж бэлтгэдэг. Хүрээ шугамыг зөв хэмжээгээр зурсан зургийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

6. Изометр проекцын аргаар дүрсэлсэн биетийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

7. Зурагт үзүүлсэн деталийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн хариуг сонгоно уу.





A. B. C. D.

8. Зурагт үзүүлсэн “Pop corn”-ны хайрцгийг диметр проекцын тэнхлэг дээр зөв байгуулсан хариуг сонгоно уу.






A. B. C. D.

9. Зурагт үзүүлсэн биетүүдийг тэгш өнцгийн проекцтой зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.



**1.** **2.** **3.**



**a.** **b.** **c.**

A. 1-a, 2-c, 3-b B. 1-a, 2-b, 3-c C. 1-c, 2-b, 3-a D. 1-b, 2-a, 3-c

10. Модон материалын хатуу, бат бэх, уян харимхай шинж чанар харилцан адилгүй байдаг. Модыг хутгаар зорох, цүүцээр шивүүлэх, хөрөөдөх, харуулдах, өөр хооронд нь харшуулж цохих зэрэг энгийн аргаар туршиж мэддэг шинж чанарыг сонгоно уу.
    A. уян налархай шинж чанар B. хатуу шинж чанар
    C. уян харимхай шинж чанар D. бат бэх шинж чанар
11. Модны ширхгийн дагуу ба хөндлөн байрлал, нягтаас хамаарч бат бэх шинж чанар нь харилцан адилгүй байдаг. Бусад төрлийн модтой харьцуулахад бат бэх шинж чанартай моднуудыг сонгоно уу.
    A. хус, шинэс B. улиас, гацуур C. нарс, хуш D. хуш, царс
12. Металлууд нь технологийн боловсруулалтад орохдоо гадны хүчний үйлчлэлд эсэргүүцэл үзүүлдэг ба эдгээр чадварыг механик чанар гэдэг. Металлын механик шинж чанаруудыг сонгоно уу.
    A. хатаах, уяраах, хат хариулах, зэврэх
    B. дулаан хадгалах, цахилгаан дамжуулах
    C. оглогдох, давтагдах, цутгагдах, гагнагдах
    D. бат бөх, хатуу, уян харимхай, уян налархай

13. Металлын гадаргууд нь тухайн материалтай харьцуулбал хатуу материал, хүчээр үйлчлэхэд эвдрэхгүй, ором гарахгүй байх чадварыг хатуу шинж чанар гэнэ. Хатуу шинж чанарыг тодорхойлох аргуудыг сонгоно уу.

    A. шахах, сунгах, нугалах, мушгих, таслах
    B. шахах, сунгах, нугалах, мушгих, цохих
    C. давтах, нугалах, цувих, мушгих, цохих
    D. багажаар зурах, огтлох, харшуулж цохих

14. Модон материалыг хэмжээний дагуу хэсэгчлэн хуваах үүрэг зориулалттай мод боловсруулах гар багажийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

15. Модон эдлэлийн холболтыг хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй гэж ангилна. Хөдөлгөөнгүй холболтод углуурга, хадаасан ба боолтын, наалтын холболтууд багтана. Трапец хэлбэрийн углуурган холболтыг харуулсан зургийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

16. Мод боловсруулах цахилгаан уран хөрөөгөөр модон материалыг хөрөөдөх технологийг харуулсан зургийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

17. Зүлгүүрдэх гэдэг нь механик боловсруулалтын нэг төрөл бөгөөд материалын гадаргууг тэгшлэх өнгөлөх зориулалттай. Модон материалын гадаргууг зүлгүүрдэх зориулалттай цахилгаан багажийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

18. Металлд гадны хүч үйлчлэхэд эвдрэхгүй, хэлбэр, хэмжээгээ өөрчлөхгүй байх чадварыг бат бөх шинж чанар гэнэ. Бат бөх шинж чанарыг тодорхойлох туршилтыг харуулсан зургийг сонгоно уу.



A. B. C. D.

19. Туслах төхөөрөмж ашиглан хуудсан металлыг нугалах технологийг харуулсан зургийг сонгоно уу.



A. B. C. D.

20. Модон эдлэлийн углуурган холболтыг үзүүрийн, тушааны, заадалт гэж ангилдаг. Углуурган холболтын ангиллыг жишээ зурагтай зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

**1.** Үзүүрийн углуурга нь бэлдцийн төгсгөлийг өнцгөөр холбох гэсэн утгатай бөгөөд (УК) гэж тэмдэглэдэг.

**2.** Тушааны углуурга нь бэлдцийн дундуур холбох гэсэн утгатай бөгөөд (УС) гэж тэмдэглэдэг.

**3.** Заадалт углуурга нь хайрцгийн булангийн заадалт холболт гэсэн утгатай бөгөөд (УЯ) гэж тэмдэглэдэг.




A. 1-a, 2-b, 3-c B. 1-b, 2-a, 3-c C. 1-c, 2-b, 3-a D. 1-b, 2-c, 3-a

21. Модон материал нь хүний биед хоргүй, эдэлгээ сайтай, боловсруулахад хялбар зэрэг давуу талуудтай тул тоглоом зохион бүтээхэд ашигладаг. Зурагт үзүүлсэн модон тоглоом хийх технологийг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.



1. Бүрдэл хэсгүүдийг хооронд нь холбож угсарна.
2. Голын том нүх болон дугуй байрлах нүхийг өрөмдөнө.
3. Бүрдэл хэсгүүдийг ширхгийн дагуу зүлгээд, будаж чимэглэнэ.
4. Бөмбөлөг болон дугуйг модны токарийн суурь машин дээр зорно.
5. Бэлдэц дээр шаблоноо буулгаж зураад, хэлбэрийн дагуу хөрөөднө.

A. 5-2-4-3-1 B. 5-2-4-1-3 C. 5-4-2-1-3 D. 5-2-3-1-4

22. Орчин үед мод ба металлын оронд хуванцар материалыг өргөнөөр хэрэглэх болсон. Хуванцар материал нь хөнгөн, гаргаж авах түүхий эд элбэг, хямд, өнгө будаг авах, боловсруулагдах чанараараа давуу талтай. Хуванцрыг реактопласт, термопласт гэсэн хоёр төрөлд хуваадаг. Реактопласт төрлийн хуванцар материалуудыг хэрэглээний жишээтэй зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

| **Хуванцарын нэр** | **Хуванцарын хэрэглээний жишээ** |
|---|---|
| 1. Полиуретан | a. цахилгаан гүйдлийг тусгаарлахад зориулсан материал, гулсах эргэвч, араа, цахилгаан техникийн эд ангиуд |
| 2. Поликарбонат | b. ихэвчлэн барилгын хана, таазны дулаалгын материал болгон хэрэглэдэг |
| 3. Текстолит | c. автомашины цонхны шилэнд наадаг хальс, компакт диск |
| 4. Фенопласт | d. цутгаж боловсруулсан цонхны хүрээ болон дулаалгын материал |

A. 1-d, 2-c, 3-a, 4-b
B. 1-a, 2-b, 3-c, 4-d
C. 1-d, 2-c, 3-b, 4-a
D. 1-b, 2-c, 3-d, 4-a

23. Хүмүүс агаарт нисэх оролдлогуудыг олноор туршиж байсан бөгөөд ихэвчлэн шувууны бүтцийг дуурайж далавч, сүүл хэрэглэсэн нь өнөөгийн онгоцны гол бүтэц болжээ. Хамгийн анхны хөдөлгүүрт нисэх онгоцыг зохион бүтээж агаарт амжилттай хөөргөсөн зохион бүтээгчийг сонгоно уу.

A. Леонардо да Винчи
B. Фокке Вульф компани
C. Вильгельм Эмиль Мессершмит
D. Уилбер Райт, Орвил Райт нар

24. Хөдөлгөөнийг нэг чигт дамжуулж, эсрэг чиглэлийн хөдөлгөөнийг түгжих үүрэг зориулалттай бөгөөд ихэвчлэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангахын тулд багаж, тоног төхөөрөмжид ашигладаг механизмыг сонгоно уу.


A.



B.


C.


D.

25. Тахир гол шатуны механизмын үүрэг зориулалт болон хэрэглээг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.



A. Эргэлдэх хөдөлгөөнийг давших буцаж шилжих хөдөлгөөн болгон хувиргах бөгөөд ихэвчлэн дотоод шаталтын хөдөлгүүрт ашигладаг.
B. Эргэлдэх хөдөлгөөнийг эргэх хөдөлгөөн болгон хувиргах бөгөөд нударганы хэлбэрээс шалтгаалан хөдөлгөөн нь өөр өөр байдаг.
C. Хөдөлгөөнийг тасалдалттай дамжуулах, хөтлөгчийн хөдөлгөөнийг багасгах үүрэгтэй бөгөөд тоолуур, цагийн механизмд өргөн ашигладаг.
D. Хөдөлгөөнийг нэг чигт дамжуулж, эсрэг чиглэлийн хөдөлгөөнийг түгжигдэг бөгөөд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангахад ашигладаг.